



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/258

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.1 д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. 2022 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Халдвар бус өвчний эрт илрүүлэг үзлэгт огт хамрагдаагүй иргэдийг хамруулах эмч нарын хамтарсан багийн сумдаар үзлэг хийх шатахууны зардалд 4.000.000 төгрөгийг, эрт илрүүлэг үзлэгээс шүдний өвчлөлгүй гарсан хүүхдийг урьдчилан сэргийлэх түрхлэг түрхэхэд шаардлагатай зардал 5.000.000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 9.000.000 (Есөн сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны "Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Сумдад ажиллах хамтарсан багийн эрт илрүүлэг үзлэгийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган мэдээ тайланг танилцуулж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Түвшинбаяр), шаардлагатай тоног төхөөрөмжийг Худалдан авах үйл ажиллагааг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6713010173